



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 229

Улаанбаатар хот

┌

Тусгай зөвшөөрөл олгох тухай

└

Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ЮЭСЖИ очлоо экспресс ХХК-д “Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 2030 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ



ГИШҮҮН.

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР